УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХАРИУЦСАН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН

2025 ОНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025.12.10. Алтай хот

| № | Хяналт шалгалт хийх чиглэл | Хяналт шалгалт хийх салбар нэгж, албан тушаалтан | Хийсэн ажлууд | Хяналт шалгалт хийсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол шийдвэр, Яам, Удирдах дээд байгууллага, аймаг орон нутгийн засаг даргын захирамж, төвийн даргын тушаал шийдвэрийн биелэлт болон төвийн хэлтэс тасаг салбар нэгжүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгана. | Хэлтсийн дарга нар<br>Салбар хариуцсан ерөнхий технологич инженерүүд | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хяналтад авсан 2 арга хэмжээг 100% гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн ажиллалаа. Тайлан болон хийсэн ажлын нотлох баримтыг ЗДТГ-т хүргүүлсэн.<br>Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой аймгийн Засаг даргын дараах захирамжууд гарсан.<br>- Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай,- Ажлын хэсэг байгуулагдан тоололгыг хналтын хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг аймгийн хэмжээнд гаргаж ЦУОШГ-т хүргүүлсэн байна.<br>- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардагдах зардал шийдвэрлэх тухай – Зардал шийдүүлэн аймгийн нутаг дэвсгэрт орж ирсэн үүлний массд нөлөөлөн орох хур тунадас нэмэгдүүлэх ажиллагааг амжилттай зохион байгуулж тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлсэн байна.<br>Засаг даргын дээрх захирамжуудыг холбогдох албан тушаалтнуудад картлан өгч, биелэлтийг улирал бүр хугацаанд нь гаргаж албан бичгээр ЗДТГазрын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан байна. | Т.Дэлгэрмаа<br>Б.Энхжаргал |
| 2 | УЦУОХ Шинжилгээний тухай хууль, Технологийн сахилгын дүрэм, Төвийн дотоод журам бусад заавар дүрэм журмын биелэлтийн хэрэгжилт. | ЗААХ<br>ЦУОТХ<br>МҮХ | Тайлант хугацаанд төвийн өртөө, харуулуудад гэнэтийн болон ээлжит шалган туслах ажлыг ЦАЗН-х ажиллагаа явуулсан сумдад зохион байгуулсан. Шалган туслах ажлаар явах бүртээ төвийн даргаар батлуулсан удирдамжийг баримтлан өртөө, харуулын ажил байдалтай танилцаж цаг уур болон ХААЦУ-ын ажиглалт хэмжилтэнд гарч байгаа алдаа дутагдал, үл тохирлыг арилгах, багаж хэмжих хэрэгслийн баталгаажуулах, заавар зөвлөмж өгөх болон сумын удирдлагуудтай уулзаж хамтран ажиллах гэрээний биелэлт цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож зарим асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.<br>Хяналт шалгалт хийхдээ цаг уурын ажиглалт хэмжилт хийх технологи мөрдөлт, ажиглалт хийх заавар журмыг баримталж байгаа эсэх болон аюулгүй ажиллагааны заавар журмыг баримталж буй эсэхэд хяналт шалгалт хийж шалган туслах ажлын акт үйлдэж баталагаажууллаа. | Т.Дэлгэрмаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | БОХЗТЛ-ийн захирал, УЦУОШТ-ийн даргаар батлуулсан графикт заагдсан баталгаажуулалтын болон шалгалт тохируулгын нийт 61 заалт бүхий ажлаас хянан баталгаажуулалтын 20, шалгалт тохируулгын 41 ажлыг баталгаажуулалтын журмын дагуу хийж гүйцэтгэн баталгаажуулалтын гэрчилгээг авч ажилласан ба хэмжих хэрэгслээс шалтгаалсан үл тохирол гараагүй болно.<br>Аймгийн хэмжээнд ашиглаж байгаа AWS 330 2 ш, AWS 310 9 ш, нийт 11 станцын мэдрүүр, төлөвийн мэдээлэл, 2025 оны засвар үйлчилгээний мэдээллийг http://192.168.100.13/currentweather/HMDTS/view_aws_service_register_center.asp цахим хуудсанд тухай бүр нь тогтмол шинэчлэн байршуулсан байна.<br>Цаг уур, ХААЦУ, гадаргын ус судлалын ажиглалт хэмжилтэд хийсэн техник, шүүмж шалгалтыг хяналтын хянацаанд нь УЦУОСМХ-ийн холбогдох хэлтсүүдэд дамжуулсан байна. | |
| 3 | Цаг уур, орчны чанарын ажиглалт, мэдээлэл үйлчилгээний ажил үйлчилгээний чанар, хүртээмж, гаргаж буй бүтээгдэхүүн үйлчилгээ | ЗААХ<br>ЦУОТХ<br>МҮХ | БОШЛаборатори нь 2025 оны эхний хагас жилд гадны 4 байгууллагын хүсэлтийн дагуу гэрээ хийж, агаар, ус, хөрсний химийн шинжилгээг хийж дүн мэдээг хүлээлгэж өгсөн. Эхний хагас жилд байгууллагад нийт 1.789.000 төгрөгний орлого оруулсан байна.<br>2025 оны эхний хагас жилд цаг агаарын мэдээ мэдээллийг авах албан тоотыг Тайшир–Гуулин усан цахилгаан станц хязгаарлагдмал хариуцлагатай компани хүсэлтийн дагуу Тайшир сумын 2024 оны 1-12 сарын цаг уурын мэдээ болон ус судлалын мэдээгээр, Хан-Өрнөд майнинг ХХК цаг агаарын мэдээ мэдээлэл авах хүсэлт ирүүлсний дагуу Төгрөг, Цээл сумдын 2014-2024 оны цаг уурын мэдээ мэдээллээр үйлчилсэн. Аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн албан тоотын хариуг Эрдэнэ сумын 2025 оны 2-р сарын 5-ны мэдээллээр албан тоотоор өгсөн. Мөн аймгийн засаг даргын тамгын газарт Есөнбулаг, Шарга, Тайшир сумдын 2015-2024 оны мэдээллийг гаргаж өгч тус тус үйлчилсэн. 2025 оны 4-р сарын 10-11-нд Эрдэнэ сумд болсон цаг агаарын гамшигт үзэгдлийн мэдээллийг Онцгой байдлын газар, Хаан банк, Алтайн торх, Цагдаагийн газар зэрэг албан газар аж ахуйн нэгжүүдэд, иргэн Ганбаатар , Давааням, Батаа нарт хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй албан тоотоор гаргаж өгч үйлчилсэн байна.<br>Цаг агаарын бодит мэдээний чанарыг сайжруулах, цахим хуудсаар танилцуулах ажлыг шинэ шатанд гаргах талаар 6 өртөөний дарга болон техникчдэд зөвлөмж өгсөний дагуу Есөнбулаг, Алтай, Бугат, Тонхил, Хөхморьт сумдын цаг агаарын бодит мэдээг видео хэлбэрээр ард иргэдийн сонирхол татсан байдлаар байршуулж эхэлсэн байна. | Т.Дэлгэрмаа<br>Б.Энхжаргал |
| 4 | Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэх. | ЗААХ | Ажилчдын цагийн бүртгэлд хяналт шалгалт хийхэд цагийн бүртгэлийг ажилчид өөр өөрийн цагийг бүртгэж хөтөлж байгаа нь дутагдалтай байна үүнийг тухайн нэг албан тушаалтанд хариуцуулан цагийг бүртгүүлэх эсвэл технологийн дэвшилтэд технологи ашиглан бүртгүүлэх. Цагийн бүртгэлд чөлөө, эрүүл мэндийн шалтгаанаар акт авсан албан тушаалтанд чөлөөний хуудас, эмчийн магадалгаа нааж баримтжуулсан нь сайшаалтай | С.Мөнхбат |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Өртөө, харуулын ээлжийн техникчид болон БОШЛ-ийн инженер техникчдэд заавар журмын дагуу аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч Синоптик инженерүүд болон Алтай өртөө, Лабораторийн албан хаагчдад өдөр бүр зааварчилгаа өгч ажилласан Мөн мотор асаах аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аянга цахилгаантай үед ажиллах зааварчилгааг өгч ажиллаж байна. Экспедиц гарах бүрт бие бүрэлдэхүүнд тогтмол зааварчилгааг өгч ажиллаж байна. | |
| 5 | Нийгмийн хамгааллын талаар хийж хэрэгжүүлж буй ажлын хүртээмж чанар | | 2025 онд сургалтын болон нийгмийн баталгааны төлөвлөгөөг батлуулан биелэлтийг улирал, хагас бүтэн жилээр тайлагнан ажилласан байна.<br>2026 төсвийн төсөл 2027-2028 оны төсвийн төсөөллийг 2025 оны 04 дүгээр сарын 21 өдрийн 83 тоот албан тоотоор ЦУОШГ-т цахимаар болон цаасаар хүргүүлсэн.<br>2025 онд 2 албан хаагч өндөр насны тэтгэвэртээ гарахаар тэтгэмжийн 51,353,000 төгрөгийг төсөвт суулгуулсан. 12 дугаар сард тэтгэмжээ олгоно.Сар бүрийн төсвийг шилэн дансны цахим сайтад байршуулсан.<br>19 албан хаагчдад нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд ажилласаны нэмэгдэл хөлсөнд 23,876,957 төгрөг, 29 албан хаагчид 27,221,274 төгрөгийн зэргийн нэмэгдэл олгосон.<br>Албаны бүх албан хаагчдад хоолны зардлыг өдрийн 13,000 төгрөгөөр 2025 оны 01 дүгээр сараас эхлэн тооцон олгож байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд нийтдээ 100,711,000 төгрөгийн хоол унааны мөнгө олгосон.<br>Албан хаагчдыг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 1, 2 дугаар улирлаар дүгнэн хангалттай үнэлгээ авсан албан хаагчдад цалингийн сандаа багтаан үр дүнгийн урамшуулал 77 албан хаагчдад 88,528,000 төгрөг олгосон.<br>Лабораторийн албан хаагчдад өдрийн 250гр-аар тооцон нормын сүү олгож байгаа бөгөөд нийтдээ 630,000 төгрөгийг зарцуулсан.<br>Хөдөлмөрийн хууль болон Засгийн газрын тогтоолын дагуу давхардсан тоогоор 32 албан хаагчдад 32,756,448 төгрөгийн шөнийн нэмэгдэл хөлс, 41 албан хаагчид 59,608,568 төгрөгийн илүү цагийн хөлсийг тооцон олгосон байна. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | 1-р улиралд 0%<br>2-р улиралд 62%<br>3-р улиралд 60%<br>4-р улиралд 80% үнэлгээ авсан. Цаашид мэдээллийн ил тод байдлыг тухайн бүр нь шинэчлэн байршуулбал зохих бүх мэдээ мэдээллийг оруулж хэвших шаардлагатай байна. Мөн ЦУОШГ-ын 2025 оны 01/794 тоот зөвлөмжөөр өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн хугацаанд нь тайлагнах шаардлагатай байна. | |
| 7 | Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих | ЗААХ | Эд хөрөнгө ашиглалтын байдалд хяналт тавьж эд хариуцагч хоорond хөрөнгө шилжсэн тухай бүр бүртгэлийг хийж байна.<br>Төвийн даргын 2025.06.16-ны өдрийн А/21, 2025.12.04-ны өдрийн А/33 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг томилуулан эд хөрөнгийг нүд үзэн тоолж, мөн хөдөө сумдаас ирүүлсэн тооллогын материалыг бүртгэлд байгаа хөрөнгөтэй тулган шалгаж дүнг баталгаажуулсан. | С.Мөнхбат<br>Ц.Болормаа |
| 8 | Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн стандарт,үйл ажиллагаа. | ЗААХ<br>Бичиг хэрэг | 2025 оны 10 дугаар сарын 01-10-ны хооронд зохион байгуулагдах Улсын үзлэг угтаж аймгийн Архивын газраас зохион байгуулсан урьдчилсан үзлэг, шалгалт манай байгууллагад 9 дүгээр сарын 18-нд ирж байгууллагын үйл ажиллагаатай танилцан үзлэг, шалгалтыг хийсэн. Тус шалгалтаар Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа – 1000-аас 993 оноо, Байгууллагын архивын үйл ажиллагааг дүгнэх үзүүлэлт – 1000-аас 860 оноо, Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт 100-аас – 83 оноо. Нийт дүнгээр 2100-аас 1936 оноо авч 92,2% үнэлэгдсэн байна. | Т.Дэлгэрмаа<br>Б.Энхжаргал |
| 9 | Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, худалдан борлуулах үйл ажиллагааг хяналт шалгалтын хуудас 2.11-ээр шалгах. | БОШЛ | 2025 оны 04 сарын 25-нд Байгаль орчны Улсын байцаагч Ш.Мөнгөнцэцэг БОШЛ-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгах талаар албан тоот ирүүлсэн. Хяналт шалгалтаар<br>1. Химиний хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байсан – 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр тусгай зөвшөөрөл авсан.<br>2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлээгүй гэсэн. Бид 3 дугаар сарын 14-нд үнэлгээг хийлгэсэн байсан.<br>3. Химийн хорт болон аюултай бодисын агуулахад эрсдлийн үнэлгээ хийлгүүлээгүй – Эрсдлийн үнэлгээг БОШЛ-ийн технологич инженер Д.Сарантуяа хийж батлуулан ажиллаж байна. | Т.Дэлгэрмаа<br>Б.Энхжаргал |

ТАНИЛЦСАН:

УЦУОШТ-ийн ДАРГА Н.АЛТАНТУЯА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН Т.ДЭЛГЭРМАА